МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

**2024 оны 4-р сарын 26, Баасан гараг | 14:00-17:30**

Монгол улсаас БНХАУ-д суугаа элчин сайдын яам

# ТОРГОНЫ ЗАМЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА - II

## АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

**Тригтек**
Утас: (976) 7737 6002
Э-мэйл: hello@trigteq.com
www.trigteq.com

Нийтэлсэн Тригтек ХХК

# АГУУЛГА

Нэг. Хөтөлбөр ........ 3

Хоёр. Зохион байгуулагчдын танилцуулга ........ 4

Тригтек ХХК ........ 4

Хятадын Азийн эдийн засгийн хөгжлийн нийгэмлэг, Уул уурхайн мэргэжлийн хороо ........ 5

Гурав. Тайлан ........ 6

Дөрөв. Хавсралт ........ 11

Төслийн хураангүй мэдээлэл ........ 11

Оролцогчдын хураангүй мэдээлэл ........ 12

Бусад ........ 14

# Нэг. Хөтөлбөр

| Хуваарь | Хөтөлбөр | Илтгэгч |
|---|---|---|
| **13:30 – 14:00** | Бүртгэл | |
| **14:00 – 14:05** | Нээлтийн үг | **Г.Цолмон**, Тригтек ХХК Гүйцэтгэх захирал |
| **14:05 – 14:10** | Нээлтийн үг | **Ц.Түмэнбаяр**, ЭСЯ-ны Худалдааны төлөөлөгч бөгөөд зөвлөх |
| **14:10 – 14:25** | Монголын уул уурхайн салбарын бодлого | **М.Мэндбаяр**, Уул Уурхайн Хүнд Үйлдвэрийн Яам, Уул уурхайн бодлогын газрын дарга |
| **14:25 – 14:40** | Монголын геологийн салбарын бодлого | **Ч.Бямбажав**, Уул Уурхайн Хүнд Үйлдвэрийн Яам, Геологийн бодлогын газрын мэргэжилтэн |
| **14:40 – 14:55** | Уул уурхайн мэргэжлийн хорооны танилцуулга | **Вэнь Жианке**, Хятадын Азийн эдийн засгийн хөгжлийн нийгэмлэг, Уул уурхайн мэргэжлийн хорооны ерөнхий нарийн бичгийн даргын орлогч |
| **14:55 – 15:15** | Цайны завсарлага | |
| **Төслийн танилцуулга** | | |
| **15:15 – 15:30** | Тайшир төсөл /Li/ | |
| **15:30 – 15:45** | Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх төсөл | |
| **15:45 – 16:00** | Геосан ХХК-ын танилцуулга | |
| **16:00 – 16:15** | Агуйт төмрийн төсөл /Ti, V/ | |
| **16:15 – 16:30** | Флюорит болон алтны төсөл | |
| **16:30 – 17:30** | Бизнес уулзалт | |

# Хоёр. Зохион байгуулагчдын танилцуулга

## Тригтек

Тригтек ХХК нь уул уурхай, олборлох салбарын өөрчлөлт шинэчлэлтэд гар бие оролцон хөгжүүлэх, олон улсад тэргүүлэгч, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилготой геологи, уул уурхайн инженерчлэлийн зөвлөх үйлчилгээний мэргэшсэн компани юм.

Бид 2021 онд БНХАУ-ын Шандун мужид бүртгэлтэй салбар компаниа үүсгэн байгуулсан бөгөөд одоогоор уул уурхайн "Интай Голд" /Yintai Gold Co., Ltd./, "Чингхай Дачайдан Майнинг" /Qinghai Dachaidan Mining Co.,Ltd./ компаниудад программ хангамж нийлүүлэх, мэргэжлийн сургалт зохион байгуулах, “Бээжингийн Геологи, Ашигт Малтмалын Институт” /BIGM/ -тэй мэргэжлийн программ хангамж борлуулах, сургалт явуулах хэлбэрээр хамтран ажиллаж байна.

Түүнчлэн Монгол улсын уул уурхайн салбарт хариуцлагатай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үндсэн зорилгын хүрээнд ашигт малтмал, уул уурхайн төсөл болон хөрөнгө оруулагчдын хамтын ажиллагааг урт хугацаанд хангах, шаардлагатай техникийн үйлчилгээг гүйцэтгэх, хууль эрх зүй болон олон улсын стандартад нийцсэн хөрөнгө оруулалтын мэргэжлийн зөвлөх үйлчилгээг үзүүлдэг.

Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний хувьд дараах ажлуудыг гүйцэтгэдэг бөгөөд үүнд:

- Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ
- Төслийн танилцуулга шинэчлэх, бэлтгэх, хөрвүүлэх
- Хөрөнгө оруулагч нартай хэлэлцээр эхлүүлэх
- Уул уурхайн хурал зөвлөгөөнд төслийг төлөөлөн оролцох
- Хөрөнгө оруулалтын нэгдсэн платформ дээр байршуулах

Одоогийн байдлаар бид хайгуул болон олборлолтын шатны нийт 20 гаруй төсөл, Канад, Англи, Хятад, Сингапур зэрэг улсын хөрөнгө оруулагчидтай хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний гэрээгээр хамтран ажиллаж байна.

## Хятадын Азийн эдийн засгийн хөгжлийн нийгэмлэг, Уул уурхайн мэргэжлийн хороо

Хятадын Азийн эдийн засгийн хөгжлийн нийгэмлэг нь 1993 онд БНХАУ-ын ГХЯ-ны удирдлага дор байгуулагдаж, Иргэний хэргийн яамнаас зөвшөөрөл авсан үндэсний хэмжээний корпорац юм. 2020 оны 8 дугаар сарын 31-ний өдөр "БНХАУ-ын Азийн эдийн засгийн хөгжлийн нийгэмлэгийн Уул уурхайн мэргэжлийн хороо" (цаашид "Азийн уул уурхайн хороо" гэх) албан ёсоор байгуулагдсан бөгөөд уул уурхайн салбарт тусгайлан үйлчилгээ үзүүлэх зорилготой.

Азийн уул уурхайн хороо нь жижиг, дунд хэмжээний уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдэд үйлчлэх эрхэм зорилгын хүрээнд эдгээр байгууллагуудад хөгжлийн шинэ загварын дагуу үйл ажиллагаагаа явуулахад дотоодын болон олон улсын сүлжээгээр дамжуулан дэмжлэг үзүүлж ажилладаг. Ашигт малтмалын эрэл хайгуулыг шинэ шатанд гаргах стратегийн ажиллагааны хүрээнд Азийн уул уурхайн хороо нь "ашигт малтмал + санхүү" гэсэн үзэл баримтлалыг удирдлага болгон, салбарын академич, профессор, холбогдох яам тамгын газар, дотоодын шилдэг 500 уул уурхайн компани, геологи хайгуулын ангиуд, тоног төхөөрөмжийн үйлчилгээ үзүүлэгч компаниуд болон хууль эрх зүйн мэргэжилтнүүдийг нэгтгэн хамтын ажиллагаа, солилцооны механизмыг бий болгож байна.

Энэхүү хамтын ажиллагааны үндсэн дээр  салбарын хөгжилд дэмжлэг үзүүлж, уул уурхайн хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах, техник технологи, хөрөнгө оруулалт, хууль эрх зүйн асуудал зэрэг мэргэжлийн цогц үйлчилгээг үзүүлдэг.

# Гурав. Тайлан

Тригтек ХХК нь "Торгоны замын хөрөнгө оруулалт: Уул уурхайн төслийн танилцуулга" арга хэмжээний цар хүрээг өргөжүүлж, Монгол улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэмжлэгтэйгээр Хятадын Азийн эдийн засгийн хөгжлийн нийгэмлэг, Уул уурхайн мэргэжлийн хороотой хамтран 2024 оны 4-р сарын 26-ний өдөр Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны дэргэдэх Монголын соёл мэдээллийн төвд дахин амжилттай зохион байгууллаа.

Нэг талаас Монгол улсын Засгийн газраас баталсан Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд гадаадын хөрөнгө оруулалт, хайгуулын салбарын үйл ажиллагааг дэмжих чиглэлд авч хэрэгжүүлж буй бодлого, хууль эрх зүйн шинэчлэлтэй холбоотой цаг үеийн шинэлэг мэдээлэл хүргэх, нөгөө талаас хөрөнгө оруулалт шаардлагатай хэтийн төлөв сайтай ордуудыг сонгон авч танилцуулах замаар Монгол Хятад хоёр улсын бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх нь энэхүү арга хэмжээний үндсэн зорилт билээ.

Монгол улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яам нь бидэнд бүхий л талаар дэмжлэг үзүүлж ирсэн бөгөөд ЭСЯ-ны Худалдааны төлөөлөгч бөгөөд зөвлөх Ц.Түмэнбаяр үг хэлж, энэ удаагийн арга хэмжээг албан ёсоор эхлүүлсэн юм.




Зураг 1. ЭСЯ-ны Худалдааны төлөөлөгч бөгөөд зөвлөх Ц.Түмэнбаяр

Монголын эрдэс баялгийн салбарын бодлого, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд, тэр дундаа уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалт, тээвэр логистик, байгаль орчны нөхөн сэргээлт зэрэг өргөн хүрээний мэдээллийг нэгтгэн Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр илтгэл тавьж, Геологийн бодлогын газрын мэргэжилтэн Ч.Бямбажав нь салбарын бодлогын хүрээнд хийгдэж буй томоохон арга хэмжээ болох хайгуулын тусгай зөвшөөрөл олгох цахим системийн талаар дэлгэрэнгүй танилцуулга хийлээ.




Зураг 3. Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр




Зураг 2. Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын мэргэжилтэн Ч.Бямбажав

Энэ удаагийн арга хэмжээг хамтран зохион байгуулагч Хятад-Азийн Эдийн засгийн хөгжлийн нийгэмлэг, Уул уурхайн мэргэжлийн хороо нь "ашигт малтмал + санхүү" гэсэн үзэл баримтлалыг удирдлага болгон, салбарын академич, профессор, холбогдох яам тамгын газар, дотоодын шилдэг 500 уул уурхайн компани, геологи хайгуулын ангиуд, тоног төхөөрөмжийн үйлчилгээ үзүүлэгч компаниуд болон хууль эрх зүйн мэргэжилтнүүдийг нэгтгэсэн, уул уурхайн хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах, техник технологи, хөрөнгө оруулалт, хууль эрх зүйн асуудал зэрэг мэргэжлийн цогц үйлчилгээг үзүүлдэг мэргэжлийн байгууллага юм. Хөтөлбөрийн дагуу тус хорооны ерөнхий нарийн бичгийн орлогч дарга Вэнь Жианке “Монгол улсад хөрөнгө оруулалт хийх боломж” сэдвээр илтгэл тавилаа.




Зураг 4. Хятад-Азийн Эдийн засгийн хөгжлийн нийгэмлэг, Уул уурхайн мэргэжлийн хорооны ерөнхий нарийн бичгийн орлогч дарга Вэнь Жианке

Хөтөлбөрийн хоёр дахь хэсэгт литий, төмөр, флюрит, болон алтны нийт 3 төсөл, нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх төсөл болон Геофизикийн судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Геосан ХХК-ны танилцуулга хийгдсэн бөгөөд алт, зэс молибден, никель-кобальт, молибден вольфрам, нүүрс зэрэг ашигт малтмалын төслүүдийг хэвлэмэл хэлбэрээр танилцуулж, хөрөнгө оруулагч болон төсөл эзэмшигчдийн бизнес уулзалтыг зохион байгууллаа.



Зураг 5. Цайны завсарлага




Зураг 6. Геосан ХХК

Энэ удаагийн арга хэмжээнд Хятад улсын уул уурхайн салбарын томоохон нийгэмлэгүүд, дотоодын болон олон улсын хамтарсан корпорацууд, хайгуул олборлолт, уул уурхайн техник технологийн үйлчилгээ үзүүлэгч 50 гаруй аж ахуй нэгжийн удирдлагууд оролцсон бөгөөд зэс, алт, цайр зэрэг өнгөт металлаас гадна жонш, газрын тос, нүүрс, тэр дундаа коксжих нүүрсний чиглэлээр хамтран ажиллах, олборлолтын шатны томоохон ордуудад хөрөнгө оруулах сонирхолтой байгаагаа илэрхийлж байсан юм.



Зураг 7. Төслийн танилцуулга

Уулзалтын үеэр хөрөнгө оруулалтын анхан шатны хэлэлцээрүүд амжилттай явагдаж, дараагийн шатанд оруулах боломжийг үүсгэсэн хэд хэдэн төслүүд, Монголд ажиллах хамтрагчаа олж анхны аман тохиролцоонуудаа хийсэн байгууллагууд гарсан нь онцлох амжилт байлаа.



Зураг 8. Бизнес уулзалт

Ийнхүү хоёрдох удаагаа зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг нэгтгэн харахад Хятад улсын хөрөнгө оруулагчдын хувьд манай улсын уул уурхайн төслүүдэд хөрөнгө оруулах, технологийн болон дагалдах үйлчилгээ үзүүлэх, хамтран ажиллах хэрэгцээ шаардлага өндөр байгаа бөгөөд бидний зүгээс цаашид үйл ажиллагааг тогтмолжуулан, төслийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллахаар төлөвлөж байна.

Бидний санаачилгыг хүлээн авч, дэмжлэг үзүүлэн ажилласан Монгол улсаас БНХАУ-д суугаа элчин сайдын яам болон хамтран зохион байгуулж, оролцсон аж ахуй нэгжийн төлөөллүүд та бүхэндээ  талархал илэрхийлье.




Зураг 9. Зохион байгуулагчид

# Дөрөв. Хавсралт

## Төслийн хураангуй мэдээлэл

| | |
|---|---|
| **Илтгэл тавьсан төслүүд** | |
| Тайшир төсөл /Li, C/ | - Газрын гадаргуу дээрх геологи болон геофизикийн судалгаа бүрэн дууссан<br>- Урьдчилсан таамаг нөөцөөр 18 мянган тонн<br>- Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр:<br>• Тунамал гаралтай Li-ийн Хайгуул төсөл дээр хамтран ажиллах |
| Агуйт төмрийн төсөл /Ti, V/ | - Газрын гадаргуу дээрх геологи болон геофизикийн судалгаа бүрэн дууссан<br>- Урьдчилсан таамаг нөөцөөр 40 сая тонн /нэмэгдэх боломжтой/<br>- Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр:<br>• Өрөмдлөгийн хайгуулын төсөл дээр хамтран ажиллах<br>• Технологийн судалгаа хамтран ажиллах |
| Хайлуур жонш болон Алтны хайгуулын төсөл | - Хайлуур жоншны ашиглалтын тусгай зөвшөөрөл 151 мянган тонн хүдэр<br>- Алтны үндсэн болон шороон ордын 8200 га талбай<br>- Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр:<br>• Эрх шилжүүлэх<br>• Хайгуулын ажил дээр хамтран ажиллах<br>• Жонш боловсруулах үйлдвэр |
| Геосан ХХК | - Агаарын геофизикийн судалгаа<br>- Чартер нислэг |
| Эрдэнэс Монгол ҮТП | - Багануурын хүрэн нүүрс дээр тулгуурласан нийлэг байгалийн хий үйлдвэрлэх төсөл |
| **Тригтек ХХК-аас санал болгож буй төслүүд** | |
| Алтны үндсэн орд | - 2.79Moz алтны нөөц / JORC / 2021 он<br>- Жилд 3 сая тонн хүдэр боловсруулах чадамжтай үйлдвэр<br>- Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр:<br>• Уурхайн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт |
| Алтны үндсэн орд | - 546Koz алтны нөөц / MRC / 2019 он, судлын төрлийн<br>- Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр:<br>• Эрх шилжүүлэх<br>• Бусад саналуудад нээлттэй |
| Молибден-Вольфрамын үндсэн орд | - 254Ktn Молибден, 61Ktn Вольфрам 2019 он, скарны төрөл<br>- Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр:<br>• Эрх шилжүүлэх<br>• Хамтарсан хөрөнгө оруулалт |
| Молибден-зэсийн үндсэн орд | - 3Ktn Молибден, 2Ktn Зэс, / MRC / 2013 он, порфирийн гарал үүсэлтэй орд нэмж тогтоох бүрэн боломжтой<br>- Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр:<br>• Хамтарсан хөрөнгө оруулалт<br>• Бусад саналуудад нээлттэй |
| Нүүрсний орд | - 41 сая.тн нүүрсний нөөцтэй, 2017 он<br>- 4300ккал/кг, хөрөнгө оруулалтаа 2.2 жилд нөхөх урьдчилсан ТЭЗҮ<br>- Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр:<br>• Худалдан борлуулах |
| Ni-Co төсөл | - Хэт суурилаг чулуулагтай холбоотой Ni-Co-ийн хүдэржилт<br>- 4130 Га талбай<br>- Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр: Нээлттэй |
| Алтны үндсэн болон шороон ордын төсөл | - Цагаан цахир ордын зэргэлдээ алтны үндсэн болон шороон ордын төсөл<br>- 13600 га талбай<br>- Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр: Нээлттэй |
| Газрын ховор элементийн төсөл | - Халзан бүрэгтэй төслийн ойролцоо<br>- Zr-Nb-Ree-ийн илрэл бүхий 7 талбай ялгагдсан<br>- Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр: Нээлттэй |
| Алт-Зэсийн үндсэн орд | - Баян айраг ордын зэргэлдээ алт болон зэсийн үндсэн ордын төсөл, Au 0.93-6.9 g/t<br>- 4300 га талбай<br>- Хөрөнгө оруулалт, хамтран ажиллах хэлбэр: Нээлттэй |

## Оролцогчдын хураангуй мэдээлэл

| # | Нэр | Байгууллага | Албан тушаал | Сонирхож буй ордуур |
|---|---|---|---|---|
| 1 | Xue Feng | Shanghai Ya Ying Shipping Co., Ltd. | Chairman | Electrolytic Copper |
| 2 | Li Qingchao | Yingda Futures Co., Ltd. Beijing Branch | Industry Manager | Coking Coal |
| 3 | Gao Xumei | Zhongteng Xuan International Investment Holdings Group | Chairman | Copper, Beryllium, Gold |
| 4 | Zhang Gongwei | Lihong Inspection Group Co., Ltd. | Deputy General Manager | Coal |
| 5 | Wang Hongxi | Beijing Haozun Technology Industry Group Co., Ltd. | Chairman | Coal |
| 6 | Zhao Haiyun | Jiangsu Far East Venture Capital Management Co., Ltd. | Chairman | Gold |
| 7 | Xiong Biao | Beijing Taizhong Technology Development Co., Ltd. | Chairman | Iron Ore, Coke Ore |
| 8 | Jiang Zhan | Kingswick Investment | Investment Director | Copper, Iron Ore |
| 9 | Jiang Tao | Zhonggang Capital | Director General Manager | Copper, Gold, Coking Coal, Uranium |
| 10 | Zhang Tingting | China International Trade Association | Director of Membership Department | Aluminum Ore |
| 11 | Li Jianwei | Deloitte Group | Consultant | Various Minerals |
| 12 | Zhu Chunxia | Dassault Systèmes (Shanghai) Information Technology Co., Ltd. | Sales Manager, Dassault Systemes Greater China Mining | Metal Ore |
| 13 | Liu Zijin | Chinese Academy of Sciences Strategic Institute | Research Assistant | Copper, Lithium, Cobalt, Nickel |
| 14 | Liu Xiaojie | Beijing Hairun Tianrui Law Firm | Partner | Coal, Gold, Aluminum, Iron, Quartzite |
| 15 | Chen Yuming | Fantongzhou Holdings Company | Mining Director | Fluorite, Copper, Iron, Coal, Gold, etc. |
| 16 | Wang Yu | Langduo Technology (Beijing) Co., Ltd. | Director of Mining Industry | Non-ferrous Metal Minerals |
| 17 | Chen Yuquan | Zhongke Zhuli Technology Group | Deputy General Manager, Overseas Business Division | Coal, Copper |
| 18 | Ma Xiaoli | Beijing Deheng Law Firm | Practicing Lawyer, Registered Geotechnical Engineer | Gold, Copper, Molybdenum |
| 19 | Yang Xiaohong | Beijing Deheng Law Firm | Practicing Lawyer | Coal, Copper |
| 20 | Li Yong | Langduo Technology (Beijing) Co., Ltd. | Deputy General Manager | Non-ferrous Metals |
| 21 | Zhao Hongjun | Indonesia Alara Nickel Mine Co., Ltd. | General Manager | Copper |
| 22 | Yue Shuyu | Beijing Lianxin Zhixiang Technology Co., Ltd. | Partner | Copper, Lead-Zinc, Lithium Resources, Phosphate, Fluorite |
| 23 | Tie Lulu | China Coal Science and Industry Group Shenyang Design Institute Co., Ltd. | Business Manager | Coal Mines, Non-ferrous Metal Mines |
| 24 | Teng Wenwei | China Coal Science and Industry Group Shenyang Design Institute Co., Ltd. | Deputy General Manager, International Engineering Business Department | Mining Engineering Design |
| 25 | Fan Zhichao | China Coal Science and Industry Group Shenyang Design Institute Co., Ltd. | Deputy Director, Market Department | - |
| 26 | Yan Han | Dassault Systèmes | Technical Consultant | Metal Ores |
| 27 | Lv Zhicheng | Development Center | Vice President | Non-ferrous Metals |
| 28 | Yang Jianjun | Sanxiang International Intelligent Technology Co., Ltd. | General Manager | Metal Ores |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 29 | Han Jilong | Development Research Center, China Geological Survey | - | Gold, Silver, Copper, Molybdenum |
| 30 | Wang Liang | Beijing Surveying Technology Engineering Co., Ltd. | Chief Engineer | Gold, Antimony, Copper, etc. |
| 31 | Qin Yingfu | Beijing Surveying Technology Engineering Co., Ltd. | Engineer | Gold |
| 32 | Zhou Wei | - | - | - |
| 33 | Song Yanjun | China International Trade Association | Head of South-South Cooperation | Gold, Aluminum, Copper Mines |
| 34 | Gao Ming | Seventh Geological Team of Henan Province | Cost Accountant | Non-ferrous Metals, etc. |
| 35 | Han Xueguang | Wanhua Mining Co., Ltd., Chaoyang, Liaoning Province | Manager | Fluorite Mines, Gold Mines |
| 36 | Wunimeng | Million Dreams | Diplomatic Experience | Fluorite Mines |
| 37 | Mengkeduren | Million Dreams | Owner | Fluorite Mines |
| 38 | Batutugel | Million Dreams | General Manager | Fluorite Mines |
| 39 | Ding Jianing | Million Dreams | Secretary | Metal Minerals |
| 40 | Song Jianzhen | Tiandiyuan Mining Beijing Office | - | - |
| 41 | Gao Ming | Henan Yudi Technology Group Co., Ltd. | Cost Accountant | |
| 42 | Nana | IIR | Overseas Marketing Manager | |
| 43 | Xiong Lianghui | Beijing Institute of Mineral Geology Co., Ltd. | Geological Engineer, | |
| 44 | Zhao Xueqing | China Mining Association | Foreign Affairs Specialist | |
| 45 | Li Yujie | China Mining Association | Director of International Cooperation and Research Department | |
| 46 | Cong Weike | China Mining Association | Chief Supervisor | |
| 47 | Ren Libo | Beijing Huaxia Jianlong Mining Technology Co., Ltd. | Sales Manager | |
| 48 | Liu Shaodong | Anhui Changfeng Mining Management Co., Ltd. | Chairman | |
| 49 | Deng Xin | Anhui Mining Federation Headquarters | President | |
| 50 | Zhang Zhenhao | Beijing Huaxia Jianlong Mining Technology Co., Ltd. | Director of Investment and Financing Department | |
| 51 | Fu Hongwu | Beijing Zhongyu Kaiming International Culture Media Co., Ltd. | Director of International Department | |
| 52 | Liu Guiying | "One Belt, One Road" Study Travel Course Writing Team | Executive Editor | |
| 53 | Zhang Guangzhong | School of International Education | Teacher | |
| 54 | Liu Wen | Chinese Summit (Beijing) Technology Co., Ltd. | Chairman | |
| 55 | Li Weiqiang | China Minsheng Zhengxing (Beijing) Technology Co., Ltd. | Director of Marketing Department | |
| 56 | Li Jiaxi | China Minsheng Zhengxing (Beijing) Technology Co., Ltd. | Assistant to the General Manager Office | |
| 57 | Lu Wanru | China Minsheng Zhengxing (Beijing) Technology Co., Ltd. | CEO | |

## Бусад

### Арга хэмжээний танилцуулга





















## Сошиал дахь нийтлэл

























